



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
АРВАНТАВДУГААР ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 06

Чингис хот

Аймгийн 2023 оны Төсөв батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Арвантавдугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Хэнтий аймгийн 2023 оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурдсанаар баталсугай:

		<i>/Мянган төгрөгөөр/</i>
1.	Аймгийн төсвийн орлого бүгд	7,899,211.6
1.1.	Татварын орлого	5,903,050.0
1.1.1.	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,000,000.0)
1.1.2.	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	470,000.0
1.1.3.	Улсын тэмдэгтийн хураамж	163,050.0
1.1.4.	Газрын дуудлага худалдаа	700,000.0
1.1.5.	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	920,000.0
1.1.6.	Аж ахуй нэгжийн албан татвар	4,650,000.0
1.2.	Татварын бус орлого	1,996,161.6
1.2.1.	Татварын бус хүүгийн орлого	1,381,730.5
1.2.2.	Бусад орлого	364,431.1
1.2.3.	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсаны орлого	250,000.0

Хоёр. Аймгийн 2023 оны төсөвт төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар баталсугай:

		<i>/Мянган төгрөгөөр/</i>
Д/д	ТЭЗ, түүний харьяа байгууллага	Орлогын дүн
2.1.	Аймгийн Засаг дарга	20,000.0
2.1.1	1. Аймгийн Засаг даргын Тамгын газар	20,000.0

Гурав. Аймгийн 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг **41,182,823.6** мянган төгрөгөөр баталж, төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагад дор, дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:

/Мянган төгрөгөөр/

3.1.	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга	657,169.0
3.1.1.	Урсгал зардлын дээд хэмжээ Үүнээс: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	542,369.0
3.1.2.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	114,800.0
3.2.	Засаг дарга	40,525,654.6
3.2.1	Аймгийн Засаг даргын Тамгын газар	3,248,242.0
3.2.1.1.	Үүнээс: Засаг даргын Тамгын газар	2,305,242.0
3.2.1.1.1	Орон нутгийн нөөц хөрөнгө	400,000.0
3.2.1.1.2	Баяр наадмын зардал	543,000.0
3.2.1.1.3	Урсгал зардлын дээд хэмжээ	16,754,917.2
3.2.1.1.4	Үүнээс: Сумдад олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ	7,956,909.2
3.2.1.1.5	Сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг	5,424,403.5
3.2.1.1.6	Орон нутгийн байгууллагын байр ашиглалтын тогтмол зардал	1,422,475.8
3.2.1.1.7	Орон нутгийн өмчийн арчилгаа, хамгаалалт, засвар үйлчилгээний төлбөр	116,537.5
3.3	Орон нутгийн өмчийн газар	215,255.1
3.4	Санхүүгийн хяналт, аудитын алба	209,185.0
3.5	Байгаль, орчин аялал жуулчлалын газар	784,438.1
3.5.1	- Байгаль, хамгаалах нөхөн сэргээх зардал	402,985.0
3.6	Халамжийн сан	152,728.0
3.7	Малыг эрсдэлээс хамгаалах сан	70,000.0
3.8	Засаг дарга данс	5,093,385.9
3.8.1	Эрсдэлийн сан	395,833.0
3.8.2	Ахмадын хороо	80,659.3
3.8.3	Нийтийн тээврийн алдагдалд олгох татаас	20,000.0
3.8.4	Засаг даргын үйл ажиллагааны зардал	1,451,000.0
3.8.5	"Тэрбум мод" үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх зардал	135,000.0
3.8.6	Эрүүл мэнд, Боловсролын салбарын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр	200,000.0
3.8.7	Дамжуулан зээлдүүлсэн зээлийн төлбөр	364,431.1
3.8.8	Улаан загалмайн хороонд дэмжлэг	10,000.0
3.8.9	Нөөцийн мах бэлтгэх зардал	80,000.0
3.8.10	Дотоодын зээлийн үйлчилгээний төлбөр	1,381,730.5
3.8.11	Орон нутгийн өмчит компанид олгох татаас	344,361.0
3.8.12	Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардал	582,871.0
3.8.13	Хог хаягдлын хураамжийн үйлчилгээний хөлс	36,000.0

3.8.14	Усан хангамжийн татаас	11,500.0
3.9	Хөрөнгийн зардлын дээд хэмжээ	15,429,109.5
3.9.1	Үүнээс: Их засвар	2,945,296.8
3.9.2	Орон нутгийн хөрөнгө оруулалт	5,876,312.3
3.9.3	Орон нутгийн хөгжлийн сан	4,917,500.4
3.9.4	Орон нутгийн замын сан	1,690,000.0

Дөрөв. Аймгийн 2023 оны төсвийн жилд аймгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлын хэмжээг **15,429,109.5** мянган төгрөгөөр баталсугай.

Тав. Аймгийн 2023 оны төсвийн жилд аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг дор дурдсанаар баталсугай:

/Мянган төгрөгөөр/

д/д	Сум/ дүүргийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	11,458,549.5
5.1.1.	Галшар	619,940.7
5.1.2.	Баянхутаг	496,331.3
5.1.3.	Баянмөнх	546,934.0
5.1.4.	Дархан	377,846.0
5.1.5.	Дэлгэрхаан	270,179.1
5.1.6.	Жаргалтхаан	587,752.0
5.1.7.	Цэнхэрмандал	515,882.0
5.1.8.	Өмнөдэлгэр	724,659.3
5.1.9.	Батширээт	527,824.6
5.1.10.	Биндэр	764,448.6
5.1.11.	Баян-Адрага	634,611.1
5.1.12.	Дадал	639,333.5
5.1.13.	Норовлин	645,527.9
5.1.14.	Батноров	808,203.1
5.1.15.	Баян-Овоо	569,013.3
5.1.16.	Мөрөн	637,102.5
5.1.17.	Бэрх	1,075,401.0
5.1.18.	Гурванбаян	366,556.2
5.1.19.	Өлзийт	217,394.6
5.1.20.	Хэрлэнбаян-Улаан	253,937.2
5.1.21.	Тахилгат	184,671.5

Зургаа. Аймгийн 2023 оны төсвийн жилд сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар баталсугай.

/Мянган төгрөгөөр/

6.1.	Сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого	3,501,640.3
6.1.1.	Хэрлэн	608,655.2
6.1.2	Бор-өндөр	2,892,985.1

Долоо. Аймгийн 2023 орон нутгийн хөгжлийн сангаас сумын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээг дор дурдсанаар баталсугай:

/Мянган төгрөгөөр/

7.1.	Нийт сумдад хуваарилах дүн	5,424,403.5
7.1.1.	Галшар	233,657.4
7.1.2.	Баянхутаг	207,802.1
7.1.3.	Баянмөнх	130,434.9
7.1.4.	Дархан	238,528.4
7.1.5.	Дэлгэрхаан	197,956.1
7.1.6.	Жаргалтхаан	172,142.3
7.1.7.	Цэнхэрмандал	219,517.5
7.1.8.	Өмнөдэлгэр	449,443.9
	Гурванбаян	54,714.5
7.1.9.	Батширээт	281,400.5
7.2.10	Биндэр	348,488.7
7.2.11	Баян-Адарга	198,988.6
7.2.12	Дадал	341,414.0
7.2.13	Норовлин	248,667.3
7.2.14	Батноров	317,752.4
	Бэрх	92,061.5
7.2.15	Баян-Овоо	228,289.3
7.2.16	Мөрөн	150,150.8
7.2.17	Хэрлэн	614,788.1
	Өлзийт	72,058.5
	Тахилгат	39,212.3
7.2.18	Бор-Өндөр	586,934.4

Найм. Аймгийн 2023 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг **41,182,823.6** мянган төгрөг буюу дор дурдсанаар баталсугай:

1. Аймгийн татварын болон татварын бус орлого **7,899,211.6** мянган төгрөг
2. Аймгийн төсөвт Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг **21,272,588.3** мянган төгрөг
3. Аймгийн Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг **10,112,403.3** мянган төгрөг
4. Орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдэл **229,500.6** мянган төгрөг
5. Аймгийн төсвийн урьд оны үлдэгдэл **1,509,119.8** мянган төгрөг

6. Аймгийн төсвийн тухайн жилийн төсвийн байгууллагын өөрийн орлого **20,000.0** мянган төгрөг
7. Мал хамгаалах сангийн урьд оны үлдэгдэл **70,000.0** мянган төгрөг
8. Орон нутгийн замын сангийн эхний үлдэгдлээс **70,000.0** мянган төгрөг

Ес. “Аймгийн төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт”-ийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Арав. “Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

Арван нэг. “Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 3 дугаар хавсралтаар баталсугай.

Арван хоёр. “Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 4 дүгээр хавсралтаар баталсугай.

Арван гурав. “Аймгийн хөрөнгө оруулалтаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх их засварын төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 5 дугаар хавсралтаар баталсугай.

Арван дөрөв. “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрөөр хийгдэх ажлын жагсаалт”-ыг 6 дугаар хавсралтаар баталсугай.

Арван тав. “Аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалт”-ыг 7 дугаар хавсралтаар баталсугай.

Арван зургаа. “Төсвийн тухай хууль”-ийн дагуу 2023 оны төсвийн хэрэгжилтийг ханган ажиллахыг сумд болон орон нутгийн төсөвт байгууллагын захирагч нарт даалгасугай.

ДАРГА



Г.ХЭРЛЭНЧУЛУУН

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
15 дугаар хуралдааны 06 дугаар
тогтоолын 01 дүгээр хавсралт

“Аймгийн төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт”

д/д	ТЕЗ, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2023 оны зорилтот түвшин		төсөв /сая төгрөг	
			Чанарын	Тоон		
1	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга					
	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа					
	1.1.1.	Шийдвэрийн хэрэгжилт, иргэдийн гаргасан өргөдөл, санал гомплын мөрөөр хяналт шалгалт хийх, хороодыг ажиллуулах	Хороодын ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг 100% ханган ажиллах	Тухай бүр		
	1.1.2.	Хэнтий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх	Хэрэгжилтийн хувь, ажлын чанарт хяналт тавих	2 удаа		
	1.1.3.	Иргэдийг соён гэгээрүүлэх, зөв хандлагыг түгээхэд чиглэсэн зорилтот ажлуудыг зохион байгуулах, дэмжих	Хэрэгжилтийг хангуулах	6 удаа		
	1.1.4.	Хурлын байгууллагын үйл ажиллагааг иргэдэд нээлттэй, ил тод байлгах, Төлөөлөгчдийг чадавжуулах	Ажлын төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх	Тухай бүр		
	1.1.5.	Хэнтий аймаг байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажилд бодлого, үйл ажиллагааны дэмждэг үзүүлж ажиллах	Төлөвлөгөөний хүрээнд	Тухай бүр		
	1.1.6.	Төлөөлөгчдийн сонгогчидтой уулзах, санал хүсэлтийг шийдвэрлэх чиглэлээр эргэх холбоог нэмэгдүүлэх	Төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	Төлөвлөгөөний заалт, тооны хувиар		
	1.1.7.	Түншлэл, харилцааг өргөжүүлэх	Хэрэгжилтийг тооцож ажиллах	Тоогоор		
	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх					
	1.2.	1.2.1.	Аймагт ГХУСАЗСЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлан хэрэгжүүлж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, ажлын уялдааг хангах	Төлөвлөгөөний дагуу ажлыг зохион байгуулах	Төлөвлөгөөний заалт, тооны хувиар	114.8
	Цагаатгах ажлыг удирдах зохион байгуулах					
	1.3	1.3.1.	Аймагт ЦАУЗБСЗ-ийн 2023 оны ажлын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангуулах	Төлөвлөгөөний дагуу ажлыг зохион байгуулах	Төлөвлөгөөний заалт, тооны хувиар	
		1.3.2.	Хэнтий аймгаас Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсэн зарим иргэдийн нөхөн олговрыг олгуулж дуусгах			

	1.3.3.	Дурсгалыг хүндэтгэх, санан дурсах өдрийг аймгийн хэмжээнд хийх, мод тарих, цагаан ном гаргах зорилтот ажил зохион байгуулах				
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагаа						
1.4.	1.4.1	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Зөвлөл, хороод, Ажлын албаны ажиллах нөхцлийг хангах, Хуралдааныг зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах	2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллах	Төлөвлөгөөн ий заалт, тооны хувиар		
	1.4.2	Хурлын 2021-2024 онд баримтлах бодлогыг зөвлөл, хороо, Ажлын албаны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх				
	1.4.3	Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Ажлын албадтай хамтарч ажиллах				
Аймгийн засаг дарга						
2	2.1	2.1.1	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хэрэгжүүлэн ажиллана.	Хэрэгжилтийг ханган ажиллана	90%	
		2.1.2	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана.			
Санхүү хяналт аудитын алба						
3	3.1	3.1.1	Төсөвт байгууллагуудад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, эрсдэлд суурилсан төлөвлөгөөт хяналт шалгалт, дотоод аудитын ажлыг тогтмолжуулан эрсдэл 15% байгааг жилд 1 хувиар бууруулахад анхаарч ажиллана.	Их, дунд эрсдэлтэй объектыг сонгон шалгаж, эрсдлийг бууруулна	75	
		3.1.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяаны 119 байгууллагын Шилэн дансны үйл ажиллагаанд тогтмол хяналт шалгалт тавьж, Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн ажиллана	Хэрэгжилтийг 100%-д хүргэж ажиллана.	119	
Орон нутгийн Өмчийн газар						
4	4.1	4.1.1	Өмчийн харилцааны талаар: Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр хяналт тавьж өмч эзэмшлийн гэрээг дүгнэх ажлыг тогтмолжуулж өмч эзэмшлийн гэрээний үр дүнг байгууллагын дарга эрхлэгч нарын жилийн ажлыг дүгнэх нэг үзүүлэлт болгож хэвших.	Хэрэгжилтийг 100% ханган ажиллана.	175	
		4.1.2	Орон нутгийн өмчит байгууллагуудаас ирүүлсэн үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх, худалдах хүсэлтийг хянан үзэж аймгийн ИТХурлын төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн, тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, нээлттэй дуудлагын худалдааны орлогыг аймгийн төсөвт төвлөрүүлэх.		Тухай бүр	
Нийгмийн халамж						
5	5.1	5.1.1	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болон амьжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тусламжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чанартай хүргэж төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэн ажиллана.	Үйлчилгээний чанар хүртээмжид анхаарч ажиллана.	100%	152.7


Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
15 дугаар хуралдааны 06 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

**“Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх
барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт”**

/Мянган төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
		Эхлэх он	Дуусах он		
Шилжих хөрөнгө оруулалт				4,062,700.0	1,241,678.0
1	Хэрлэн голын гүүрнээс Ханбүргэдийн уулзвар хүртэл авто замын засвар, тохижилт гэрэлтүүлэг	2022	2023	2,300,000.0	145,978.5
2	Цанын баазын зураг төсөл /Биндэр сум/	2022	2023	20,000.00	20,000.0
3	Зураг төсвийн зардал	2022	2023	100,000.00	100,000.0
4	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрыг дулааны төвлөрсөн шугамд холбох	2022	2023	192,700	125,700.0
5	Төв цэнгэлдэх хүрээлэнгийн гаднах зам, талбайн тохижилт	2022	2023	1,450,000.00	850,000.0
Шинэ хөрөнгө оруулалт				7,121,448.9	4,346,633.9
6	Пүрэвжавын гудамжны авто замыг Цагдаагийн уулзвараас урагш явсан авто замтай холбох зам	2023	2024	1,900,000.00	1,100,000.0
7	Хөдөө аж ахуйн хөгжлийн төвийн тохижилт	2023	2023	410,000.0	205,000.0
8	Авто зогсоолуудын хучилт /Хэрлэн сум/	2023	2024	800,000.00	500,000.0
9	Гүйлтийн зам, хөл бөмбөгийн талбайн зүлэг, тохижилт /Хэрлэн сум/	2023	2024	1,267,703.90	800,000.0
10	Чингисийн талбайн индэрийн лэд дэлгэц	2023	2023	50,000.00	50,000.0
11	Багийн төвийн барилга /Биндэр сум, Баян-Өндөр баг, Галшар сум Оч баг/	2023	2024	193,745.00	100,000.0
12	Хэнтий аймгийн музейн үзүүлэлэг дэглэлт хийх	2023	2024	400,000.0	200,000.0
13	Эрүүл мэндийн тоног төхөөрөмж	2023	2023	225,000.0	225,000.0
14	Эрүүл мэндийн төвд автомашин /Дэлгэрхаан сум, Хэрлэнбаян улаан тосгон, Баянхутаг, нэгдсэн эмнэлэг/	2023	2023	60,000.0	60,000.0
15	Мал эмнэлгийн лабораторийн тоног төхөөрөмж	2023	2023	68,000.0	68,000.0
16	Улсын бүртгэлийн баримтыг архивт хадгалах нягтаршуулсан шүүгээ	2023	2023	40,000.0	40,000.0
17	Төв цэнгэлдэх хүрээлэнгийн доторх хүний суудал, суудлын суурийн ажил	2023	2024	2,200,000.00	1,086,633.9
18	Хот тохижилтын тоног төхөөрөмж /Хэрлэн сум/	2023	2023	300,000.00	200,000.0
ДҮН				11,977,148.9	5,876,312.3

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
15 дугаар хуралдааны 06 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт



“Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт”

/Мянган төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн
		Эхлэх он	Дуусах он		
Шилжих төсөл арга хэмжээ				2,342,760.8	1,490,000.0
1	Гэр хорооллын хайрган хучилттай авто замын засвар /Хэрлэн сум/	2022	2023	360,000.0	250,000.0
2	Замын нөхөөс, явган хүний гэрлийн дохио /Хэрлэн сум/	2022	2023	100,000.0	40,000.0
3	4-н зам-Хишигийн уулзвар-Хэрлэн зоогийн уулзвар хүртлэх зам	2022	2023	1,770,000.0	1,140,000.0
4	4-р цэцэрлэгийн гадна зам, зогсоол	2022	2024	112,760.8	60,000.0
Шинээр хэрэгжих төсөл арга хэмжээ				370,000.0	200,000.0
5	Замын нөхөөс, засвар /Цэнхэрмандал сум/	2023	2023	20,000.0	20,000.0
6	Авто тээврийн уулзвараас цаг уурын уулзвар хүртлэх авто замын засвар	2023	2024	350,000.0	180,000.0
ДҮН				2,712,760.8	1,690,000.0

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
15 дугаар хуралдааны 06 дугаар
тогтоолын 4 дүгээр хавсралт



“Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”

/Мянган төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Хамрах салбар	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
			Эхлэх он	Дуусах он		
Шилжих төсөл арга хэмжээ					4,219,434.0	2,899,395.1
1	Дулааны станцын ус хангамж ариутгал татуургын зураг төсөл	Эрчим хүчний салбар	2021	2023	36,176.0	36,176.0
2	2-р хэлхээний шугам сүлжээний зураг төсөл	Эрчим хүчний салбар	2021	2023	30,000.0	30,000.0
3	Төв гудамж, талбай камержуулалт /Дадал сум /	Харилцаа холбооны салбар	2022	2023	99,800.0	49,900.0
4	2-р багийн худаг, цэвэр усны шугам, ухаалаг систем /Хэрлэн сум /	Нийтийн аж ахуйн салбар	2022	2023	65,000.0	65,000.0
5	Дулааны станцын цахилгааны ТЭЗҮ /Хэрлэн сум/	Эрчим хүчний салбар	2022	2023	100,000.0	30,189.5
6	Шинэ суурьшлын бүсэд 0.4-ийн агаарын шугам байгуулах /Батноров сум/	Эрчим хүчний салбар	2022	2023	406,458.4	301,130.0
7	Төв цэнгэлдэхийн их засвар /Хэрлэн сум/	Биеийн тамир спортын салбар	2022	2023	1,700,000.0	1,370,000.0
8	Шинэ суурьшлын бүсэд 0.4-ийн агаарын шугам байгуулах /Хэрлэн сум 2-р баг/	Эрчим хүчний салбар	2022	2022	292,000.0	212,000.0
9	Сур харвааны талбайн их засвар /Хэрлэн сум/	Биеийн тамир спортын салбар	2022	2023	360,000.0	260,000.0
10	Баатруудын гудамжны Ногоон байгууламж бүхий жишиг гудамжны тохижилт /Хэрлэн сум/	Хот байгуулалтын салбар	2022	2023	400,000.0	100,000.0
11	"Монголын эзэнт гүрний мини парк" тохижилт, гэрэлтүүлэг, гадна цахилгаан хангамж	Хот байгуулалтын салбар	2022	2023	730,000.0	445,000.0
Шинээр эхлэх төсөл арга хэмжээ					4,687,719.3	2,018,105.3
12	Соёлын төвийн дээврийн их засвар /Баян-Адрага сум/	Соёлын салбар	2023	2024	181,151.5	50,000.0
13	Сумын төвийн гэр хорооллын гэрэлтүүлэг /Баянмөнх сум/	Хот байгуулалтын салбар	2023	2024	99,073.5	40,000.0
14	Хөдөлмөр зуслангийн амралтын цахилгаан дамжуулах агаарын шугам /Баян-Овоо/	Эрчим хүчний салбар	2023	2024	83,632.8	40,000.0

15	Хогийн цэгийг цэгцлэх, хашаажуулах /Баянхутаг сум/	Байгаль орчны салбар	2023	2024	92,400.0	45,000.0
16	3-р цэцэрлэгийн гадна фасадын их засвар /Бор-Өндөр сум/	Боловсролын салбар	2023	2024	148,800.0	50,000.0
17	Бор-Өндөр цогцолбор сургуулийн дотуур байрны гадна фасадын засвар	Боловсролын салбар	2023	2024	181,102.8	60,000.0
18	Хүүхдийн тоглоомын талбай, тохижилт /Галшар сум/	Хот байгуулалтын салбар	2023	2024	202,626.6	91,054.9
19	Спорт цогцолборын барилгын гадна тохижилт /Дадал сум/	Биеийн тамир спортын салбар	2023	2024	214,123.3	102,342.4
20	"Шинэ суурьшлийн бүс"-ийн 04 кв-н цахилгаан хангамж /Дадал сум/	Эрчим хүчний салар	2023	2024	151,664.9	80,000.0
21	Яруу найрагч Р.Чойномын гэр музейн барилгын их засвар /Дархан сум/	Соёлын салбар	2023	2024	165,951.9	50,000.0
22	ЕБС-ийн дотуур байрны барилгын их засвар /Хэрлэнбаян-Улаан тосгон/	Боловсролын салбар	2023	2024	132,651.8	60,000.0
23	Сумын төвийн гэрэлтүүлэг /Жаргалтхаан сум/	Хот байгуулалтын салбар	2023	2024	87,000.0	50,000.0
24	Соёлын төвд тоног төхөөрөмж /Мөрөн сум/	Соёлын салбар	2023	2023	59,914.7	59,914.7
25	Шинэ суурьшлын бүсэд 04 кв-ын агаарын шугам татах /Мөрөн сум/	Эрчим хүчний салбар	2023	2024	91,342.0	40,000.0
26	Сумын төвийн гэрэлтүүлэг /Норовлин сум/	Хот байгуулалтын салбар	2023	2024	180,422.5	60,000.0
27	Халуун ус, эко ариун цэврийн байгууламж /Өмнөдэлгэр сум/	Нийтийн аж ахуйн салбар	2023	2024	150,000.0	70,000.0
28	Багийн төвийн цахилгаан хангамж 35/04 кв-ын АТП, 04 кв-ын ЦДАШ угсрах /Цэнхэрмандал сум, Хужхан баг/	Эрчим хүчний салбар	2023	2024	112,372.0	50,000.0
29	Булаг багийн цахилгаан хангамжын шинэчлэл, гэрэлтүүлэг /Хэрлэн сум/	Эрчим хүчний салбар	2023	2024	617,091.6	166,343.5
30	Төв цэнгэлдэх хүрээлэнгийн индэр, ариун цэврийн байр, агуулах, хувцас солих байр, гадна шугам сүлжээ, гэрэлтүүлэг /Хэрлэн сум/	Биеийн тамир спортын салбар	2023	2024	878,293.6	506,235.3
31	8 аваргатай цэцэрлэгт хүрээлэнгийн засвар, тохижилт /Хэрлэн сум/	Хот байгуулалтын салбар	2023	2024	472,605.7	83,884.1
32	Жишиг гудамжны цахилгаан хангамж /Хэрлэн сум/	Хот байгуулалтын салбар	2023	2024	152,257.4	70,000.0
33	Гэр зуслангийн гадна цахилгаан хангамж /Хэрлэн/	Эрчим хүчний салбар	2023	2024	199,040.4	159,130.4
34	Цамхагт гэрэлтүүлэг, камержуулалт /Хэрлэн сум 6-р баг	Хот байгуулалтын салбар	2023	2023	34,200.0	34,200.0
ДҮН					8,907,153.3	4,917,500.4

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
15 дугаар хуралдааны 06 дугаар
тогтоолын 5 дугаар хавсралт

“Аймгийн хөрөнгө оруулалтаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх их засварын төсөл, арга хэмжээний жагсаалт”

/Мянган төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг		Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн
		Эхлэх он	Дуусах он		
Шилжих төсөл арга хэмжээ				5,190,600.0	1,150,327.7
1	Орон сууцын байруудын дээврийн их засвар /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/	2022	2023	236,000.0	38,000.0
2	Сургуулийн барилгын их засвар /Хэнтий, Баян-Адарга сум/	2022	2023	755,600.0	100,000.0
3	Сургуулийн барилгын их засвар /Хэнтий, Баян-Овоо сум/	2022	2023	984,000.0	354,327.7
4	Халдвартын эмнэлгийн их засвар /Хэнтий, Хэрлэн сум/	2022	2023	250,000.0	74,700.0
5	Сургуулийн барилгын их засвар /Дархан сум/	2022	2023	280,000.0	50,000.0
6	1-р цэцэрлэгийн барилгын дээврийн засвар, фасадны дулаалгын ажил /Бор Өндөр сум/	2022	2023	418,000.0	50,000.0
7	Захирагчийн ажлын албаны байрны засвар /Өмнөдэлгэр сум Гурванбаян тосгон/	2022	2023	313,000.0	50,000.0
8	Дотуур байрны засвар /Өмнөдэлгэр сум/	2022	2023	518,800.0	47,000.0
9	Соёлын төвийн барилгын их засвар /Хэнтий, Хэрлэн сум, Өлзийт тосгон/	2022	2023	448,900.0	50,000.0
10	Соёлын төвийн барилгын их засвар /Хэнтий, Хэрлэн сум, 5-р баг/	2022	2023	414,300.0	114,300.0
11	"Тэмүүжин" Цогцолбор сургуулийн фасадны засвар, тохижилт /Хэнтий, Хэрлэн сум/	2022	2023	100,000.0	50,000.0
12	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Хэнтий, Баянхутаг сум/	2022	2023	472,000.0	172,000.0
Шинээр хэрэгжих төсөл арга хэмжээ				3,777,575.5	1,794,969.1
13	Эрүүл мэндийн төвийн засвар /Баянмөнх сум/	2023	2024	304,000.00	173,000.00
14	Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Дэлгэрхаан сум/	2023	2024	687,791.2	396,369.1
15	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны их засвар /Жаргалтхаан сум/	2023	2024	293,635.3	146,000.0
16	Эрүүл мэндийн төвийн засвар /Хэнтий, Мөрөн сум/	2023	2024	345,265.6	179,000.0
17	Сургуулийн барилгын их засвар /Цэнхэрмандал сум/	2023	2024	567,984.8	200,000.0

18	Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчдын 4-н айлын орон сууцны барилгын их засвар /Дархан сум/	2023	2024	184,368.32	40,000.0
19	Хан Хэнтий цогцолбор сургуулийн дээврийн засвар /Хэрлэн сум/	2023	2024	360,000.0	235,600.0
20	Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны их засвар /Батноров сум, Бэрх тосгон/	2023	2024	577,433.1	195,000.0
21	4-р сургуулийн цонхны засвар /Хэрлэн сум/	2023	2024	457,097.2	230,000.0
ДҮН				8,968,175.5	2,945,296.8

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
15 дугаар хуралдааны 06 дугаар
тогтоолын 6 дугаар хэвсрэлт

**“Аймгийн засаг даргын 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагаа
хөтөлбөрийн жагсаалт”**

/Мянган төгрөгөөр/

№	ТӨРИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТЭС			
	Үйл ажиллагаа	Төсөв	Арга хэмжээ	Төсөв
1	Төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангана.	70,000.0	Сумдын Засаг даргын Тамгын газар, Хот, тосгоны захирагчийн ажлын алба, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Архивын тасаг зэрэг иргэдэд төрийн үйлчилгээг шууд хүргэдэг байгууллагуудын албан хаагч нарын үйл ажиллагааг иргэн үнэлдэг төхөөрөмж, дуу, дүрсний хяналтын системийг нэвтрүүлнэ.	12,000.0
2	Иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж төрийн байгууллагын ил тод байдлыг хангах "Иргэдийн оролцоот-Хэтийн Хэнтий" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	50,000.0	Төрийн албан хаагчдын хэрэгцээ, шаардлагад үндэслэн "Танхимын болон цахим сургалт"-ын нэгдсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж тухай бүр түвшинг тогтооно.	10,000.0
3	Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймаг орон нутгийн онцлогт тохируулан жил бүр боловсруулан "Эрх бүхий албан хаагчдын баг"-аар дамжуулан хэрэгжилтийг зохион байгуулна.	5,000.0		
ДҮН		125,000.0		22,000.0
№	НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС			
	Үйл ажиллагаа	Төсөв	Арга хэмжээ	Төсөв
1	Сумдад нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг зохион байгуулна.	20,000.0	"Чадварлаг багш, чанартай боловсрол" арга хэмжээний хүрээнд жил масс сургалтын чанарын үнэлгээ хийж, шалгарсан сургууль цэцэрлэгийг шагнаж урамшуулна	45,000.0
2	Орон нутгийн төсвийг үр ашигтай зарцуулах, шигшээ багийн үйл ажиллагааг чанаржуулах зорилгоор	150,000.0	"Эрчүүдийн эрүүл мэнд" арга хэмжээг зохион байгуулж, нийт эрчүүдийн 60-с доошгүй хувьд хүрч ажиллана.	10,000.0

	Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг клубын системд шилжүүлнэ			
3	Хүүхдэд ээлтэй орон нутгийн 6 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжиж, эрсдэлд нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлж Хүүхдэд ээлтэй орон нутаг болно.	85,000.0	"Эрүүл ирээдүй" арга хэмжээг зохион байгуулна.	13,000.0
4	Монгол үндэсний спортын уламжлалт соёлыг дээдэлж, орон нутагт зохион байгуулах арга хэмжээнд дэмжлэг үзүүлнэ	20,000.0	Үндэсний болон спортын их наадам зохион байгуулна.	60,000.0
5	Төр-Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.	110,000.0	Аймгийн 100 жилийн ойн арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд "Чингис хаан дуулалт жүжиг" бүтээлийг туурвихад дэмжлэг үзүүлж, олны хүртээл болгоно.	42,000.0
6	Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагаагаар дамжуулан жил тутам залуучуудын оролцоог 50 хувиар, үйл ажиллагаанд хамрагдалтыг 10 хувиар нэмэгдүүлнэ.	45,000.0	Жендэрийн чиглэлээр орон нутагт тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчдод цогц үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	50,000.0
7	Нийтийг хамарсан үндэсний болон нийтийн биеийн тамир, бүх нийтийн спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудыг түшиглэн биеийн тамираар хичээллэгсэдийг нэмэгдүүлнэ.	20,000.0	Иргэдийг соён гэгээрүүлэх, хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэхэд бүх нийтийн оролцоог хангаж "Хэнтийн түүх – бидэнд чухал" арга хэмжээг жил бүр зохион байгуулах	55,000.0
8	Орон нутагт шаардлагатай мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлнэ.	70,000.0	Шаардлагатай сургууль, цэцэрлэг, дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулж зориулалтын тоног төхөөрөмжөөр хангана.	28,500.0
ДҮН		520,000.0		303,500.0
№	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС			
	Үйл ажиллагаа	Төсөв	Арга хэмжээ	Төсөв
1	"Цагаан сар-Цагаан идээ", "Хэнтийн намрын ногоон өдрүүд" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах	10,000.0	"Хүнсний хувьсгал" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх.	47,500.0
2	Монгол мал-II арга хэмжээг хэрэгжүүлж, баталгаажсан үүлдэр, омгийн малын үзлэг ангилалт хийх	25,000.0	Голомтын ариутгал, халдваргүйтгэл	3,000.0
3	Аялал жуулчлал, нийтийн аж ахуй, барилга, дэд бүтэц, дулаан эрчим хүч, харилцаа холбоо, уул уурхай, бичил уурхай, мал эмнэлэгийн салбарын зөвлөгөөн сургалт, арга хэмжээ	50,000.0	Агаарын чанарын бүсэд бохирдол хэмжигч багаж тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх (спектрофотометр, агаараас хий соруулах mini pump)	16,500.0

4	Агаарын бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тооллого зохион байгуулах, хяналт тавих	2,000.0	"ITM" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн болон аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүд зохион байгуулах.	35,000.0
5	"Бүс нутгийн брэнд бүтээгдэхүүн ба экспортын чиг хандлага" зүүн бүсийн сургалт, зөвлөгөөн, үзэсгэлэн зохион байгуулах	20,000.0		
ДҮН		107,000.0		102,000.0
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС				
№	Үйл ажиллагаа	Төсөв	Арга хэмжээ	Төсөв
1	Терроризмтой тэмцэх зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх /ном хэвлүүлэх, өрөө тохижуулах, зөвлөгөө өгөх/	5,000.0	Бүх нийтийн эрх зүйн боловсролын хүрээнд иргэд, аж ахуй нэгж байгууллага бүрд хүрч холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтыг төрийн бус байгууллагатай хамтарч зохион байгуулах /сургалт, сурталчилгаа, гарын авлага боршур/	10,000.0
2	Чингис хотын хэмжээнд камерын сэргээн засвар, арчилгааг тогтмолжуулах.	5,000.0	"Архидалтгүй хэтийн Хэнтий" арга хэмжээг зохион байгуулна /Эмийн эмчилгээ, албадан эмчилгээ, сургалт, сурталчилгаа/	35,000.0
3	Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагаанд шаардлагатай байгаа техник, тоног төхөөрөмжөөр хангах.	9,000.0	Иргэдийн эрх ашгийг хамгаалах ажлын хүрээнд ялтан хөдөлмөрлөх нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	23,000.0
4	Төрийн архивыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж мэдээллийн эргэлтийн санг нэмэгдүүлэх.	22,000.0	Хилийн 0287 дугаар ангийн хилчдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор шаардлагатай тоног төхөөрөмжөөр дэмжлэг үзүүлэх.	23,500.0
5	4.1.5 Хууль сахиулах байгууллагын алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд цагдаагийн албан хаагчдын ажиллах нөхцөлийн сайжруулахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх	42,000.0		
6	Хилийн шугамын дагуу мөр хянах болон түймрээс урьдчилан сэргийлэх шороон зурвасыг сэргээх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	3,000.0		
7	"Хяналт шалгалт"-ийн арга хэмжээний төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг хангаж ажиллана.	10,000.0		
ДҮН		96,000.0	-	91,500.0
ЦЭРГИЙН ШТАБ				
№	Үйл ажиллагаа	Төсөв	Арга хэмжээ	Төсөв

1	Батлан хамгаалах яамтай хамтран зүүн бүсийн аймгуудын сумын ЗДТГ-ын дарга нартай Орон нутгийн хамгаалалтын команд штабын сургууль зохион байгуулах	20,000.0		
2	Зэвсэгт хүчний 102 жилийн ой, "Монгол цэргийн өдөр"-ийг тохиолдуулан төрийн цэргийн болон хууль хүчний байгууллага, хүүхэд залуучуудын дунд тэмцээн уралдаан, ёслолын арга хэмжээ зохион байгуулах	6,000.0		
3	Аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын дунд цэрэгжлийн спортын "Дөл" цогцолбор тэмцээнийг 3 үе шаттайгаар зохион байгуулж, улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох	13,000.0		
4	Батлан хамгаалах бодлого зорилтыг сурталчлах, хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэх арга хэмжээг төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах	5,000.0		
ДҮН		44,000.0		
№	ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС			
	Үйл ажиллагаа	Төсөв	Арга хэмжээ	Төсөв
1	Төрийн албанд ISO: 9001 стандарт нэвтрүүлэх	3,000.0	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөн туслах	15,000.0
		3,000.0		15,000.0
САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС				
1	Сум хөгжүүлэх сан, Жижиг дунд бизнесийн зээлийн эргэн төлөлтийг сайжруулах ажлыг эрчимжүүлэхээр сумдад ажиллах.	22,000.0		
НИЙТ ДҮН		917,000.0		534,000.0
		НИЙТ ДҮН		1,451,000.0



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
15 дугаар хуралдааны 06 дугаар
тогтоолын 7 дугаар хавсралт

"Аймгийн 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэх Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргэх арга хэмжээний ажлын жагсаалт"

/Мянган төгрөгөөр/

Д/д	ТӨЗ, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Нийт Зардал /мян.төг/
Байгаль орчин аялал жуулчлалын газар						
1.Усны нөөц хамгаалах чиглэлээр						
1.1	Уст цэгийн тоо бүртгэлийг зохион байгуулж, Улсын усны мэдээллийн санд оруулах	УГГХДТСГЗ	1	удаа	5,000.0	5,000.0
		ХГСГЗ	1	удаа	15,000.0	15,000.0
		ОУГСГЗ	1	удаа	12,000.0	12,000.0
1.2	Усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын бүсийг тогтоох, тэмдэгжүүлэлт хийх	УГГХДТСГЗ	20	ш	500.0	10,000.0
		ХГСГЗ	20	ш	500.0	10,000.0
		ОУГСГЗ	20	ш	500.0	10,000.0
1.3	Усны сан бүхий газар, булаг шанд, рашааны эхийг хашиж, гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх	УГГХДТСГЗ	2	ш	9,000.0	18,000.0
		ХГСГЗ	2	ш	9,000.0	18,000.0
		ОУГСГЗ	4	ш	6,000.0	16,000.0
1.4	Гадаргын усны нөөц , зэрлэг ан амьтанд зориулсан усан орчинг нэмэгдүүлэх зорилгоор хөв цөөрөм сэргээн засварлах зураг төсөв хийх	Дархан сум	1	удаа	15,000.0	15,000.0
1.5	Хөв цөөрөм сэргээн засварлах, эргийн хамгаалалт хийх	Аймгийн хэмжээнд	1	удаа	70,000.0	70,000.0
1.6	Байгаль хамгаалагчдыг чадавхижуулах сургалт	Аймгийн хэмжээнд	1	удаа	8,000.0	8,000.0
1.7	Усны тухай хууль болон холбогдох журмын хэрэгжилтийг хангах зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сургалт сурталчилгаа хийх	Аймгийн хэмжээнд	1	удаа	3,000.0	3,000.0
1.8	Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Аймгийн хэмжээнд	4	удаа	2,500.0	10,000.0
1.9	Ус ашиглагч аж ахуйн нэгжид холбогдох байгууллагуудтай хамтарсан зөвлөн туслах ажлыг зохион байгуулах	Сав газарт хамаарагдах 12 сумдад	1	удаа	4,000.0	4,000.0
1.10	Ач холбогдол бүхий гадаргын усанд судалгаа шинжилгээ хийх /Хөх нуур, Гүрмийн нуур, Аваргын гол, Цэнхэрийн гол, Гүн бүрд нуур, Мөрөнгийн гол, /	5 сумын тус бүр нэг гадаргын уст цэг	1	удаа	8,000.0	8,000.0
1.11	Усны сан бүхий газрын эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх	Цэнхэрмандал	10	га	2,000.0	20,000.0

1.12	Хэрлэн голын татмын бургасан ойд нөхөн сэргээх шаардлагатай газар, голын онцгой болон энгийн хамгаалалтын бүсэд эвдэрсэн газрын талбайг тодорхойлох судалгааг хийх	Хэрлэн гол дагуу	1	удаа	5,000.0	5,000.0
1.13	Хэрлэн голын татмын бургас доройтсон газарт бургасны нөхөн тарилт хийж хамгаалах	Баян-Овоо	5	га	2,800.0	14,000.0
1.14	Хэрлэн голын урсцыг бүрэлдэх голуудыг орон нутгийн болон улсын хамгаалалтад авах асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэх	Аймгийн хэмжээнд	1	удаа	1,000.0	1,000.0
Хөрсний доройтол, орчны бохирдолыг бууруулах						
1.15	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний 1-р үе шат хэрэгжүүлэх	Аймгийн хэмжээнд	1	багц	130,985.0	130,985.0
ДҮН					402,985.0	
2. Ойн нөөцийг нөхөн сэргээх, хамгаалах чиглэлээр						
Дүн					264,350.0	
3. Амьтан хамгаалах чиглэлээр						
Дүн					160,000.0	
4. Тусгай хамгаалалттай газар нутаг, уул уурхайн нөхөн сэргээлтийн чиглэлээр						
Дүн					129,015.0	
НИЙТ ДҮН					956,350.0	